



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 7/210

Мандалговь

Газар эзэмших эрхийг
шилжүүлэх тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1,2,4 дэх заалт, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Их тойруу-6 гудамж 604 тоот) байршилтай "Өлзий-Дундговь" ХХК (РД:2012162)-ийн үйлчилгээний зориулалттай 27329 м.кв (2,7329 га) газраас 440 м.кв (0,044 га) газрыг иргэн Баяр овогтой Бадамгарав (ЗЮ:57061577)-т (Их тойруу-6 гудамж, 604а тоо хаягт) амины орон сууцны зориулалтаар нь 20 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр эрхийг шилжүүлж, үлдсэн газрыг 24359 м.кв (2,4359 га)-р тогтоож "Өлзий-Дундговь" ХХК (РД:2012162)-д зориулалтаар нь 20 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх байгууллагуудтай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2008 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн 117 дугаар захирамжийн холбогдох хэсэг мөн газар эзэмших 0077032 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190550